| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | |
| Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 10,407,334.00 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 69,964,759.55 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| Төсвөөс гадуур байгууллага | | |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 81.00 | 81.00 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 50.00 | 50.00 |
| Үйлчлэх ажилтан | 30.00 | 30.00 |
| Гэрээт ажилтан | | |
| **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 51.00 | 51.00 |
| **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 51.00 | 51.00 |
| Төрийн өмчит ЕБС | 51.00 | 51.00 |
| Хувийн ЕБС | | |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **81.00** | **81.00** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | |
| Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| Ажлын албаны албан хаагч (АА) | | |

| | | |
|---|---|---|
| СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 49.00 | 49.00 |
| ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| Соёл урлагийн салбарын тєрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 31.00 | 31.00 |
| Гэрээт ажилтан | | |
| Улс төрийн албан хаагч (УТ) | | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага дунд боловсрол олгох чиг үүрэг бүхий байгууллага. Сургуулийн тайлант оны зорилгыг “Хүүхдийг суралцах, хөгжих тэгш боломжоор хангах, эрүүл, аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэн, сургууль, багш, эх, асран хамгаалагч, суралцагчдын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, багшийн хөгжлийг дэмжих оновчтой менежментийг хэрэгжүүлнэ“ гэж тодорхойлсон байна.

Зорилгыг биелүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.Үүнд:

Зорилт1: Бие даан суралцаж, хөгжих зорилготой хүүхдийг төлөвшүүлэх

Зорилт2: Суралцах таатай орчин бүрдүүлж, бүх талын хамтын ажиллагааг сайжруулах

Зорилт3: Багшийн хөгжлийг дэмжсэн оновчтой менежментийг хэрэгжүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага. Сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны 11 сарын 02-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5293.6 сая төгрөгөөр буюу 6.9 дахин өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,407.30 | 69,964.70 | (59,557.40) |
| Авлага | | | - |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 70,510.60 | 57,145.90 | 13,364.70 |
| Үндсэн хөрөнгө | 809,610.70 | 6,057,032.60 | (5,247,421.90) |
| **Нийт хөрөнгө** | **890,528.60** | **6,184,143.20** | (5,293,614.60) |
| Өр төлбөр | 7550.1 | 15472.8 | (7,922.70) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 882,978.50 | 6,168,670.40 | (5,285,691.90) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **890,528.60** | **6,184,143.20** | (5,293,614.60) |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 69.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 59.5 сая төгрөгөөр өссөн байна.Зарцуулагдаагүй төсвийн дийлэнх үлдэгдлийг цалингийн зардал болон үдийн хоол, дотуур байрны хоолны, бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

Бараа материалын үлдэгдэл 13.4 сая төгрөгөөр буурсан байна.Төсвийн хөрөнгөөр 161.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 166.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 1.4 сая төгрөгийн бараа материалыг ажилчдад олгож, 0.6 сая төгрөгийн малыг нядалж, хүнсэнд шилжүүлж, холбогдох газрын шийдвэрээр 7.5 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 5247.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Төсвийн хөрөнгөөр 39.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 5314.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна. Тухайлбал: Сургуулийн шинээр баригдаж байгаа 5160.2 сая төгрөгийн дуусаагүй барилгыг, боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 120.9 сая төгрөгийн эко 00-ыг, бусад эх үүсвэрээр 33.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 87.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна. Шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй байна.Үндсэн хөрөнгөд 105.8 сая төгрөгийн элэгдэл байгуулж, акталсан хөрөнгийн 87.2 сая төгрөгийн элэгдлийг данснаас хассан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 5285.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 986.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 986.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 1146.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 2132.4 сая төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1654.2 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 465.9 сая сая төгрөгийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1.9 сая төгрөгийн санхүүжүүлэхээр нийт 2122.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1654.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 453.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1.9 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2051.8 сая төгрөг буюу 96.2 хувьтай, дансанд 69.9 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна.Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 2,860.00 | 2,860.00 | 0.00 | 100.00 |
| 80312 | Сургалт семинар | 1,430.00 | 1,430.00 | 0.00 | 100.00 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 2860.0 | 1653.5 | 1,206.50 | 57.81 |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 57665.4 | 51832.5 | 5,832.90 | 89.88 |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 132413.8 | 125776.9 | 6,636.90 | 94.99 |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 32459.1 | 32451.3 | 7.80 | 99.98 |
| 81823 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 6435.1 | 6435.1 | 0.00 | 100.00 |
| 81827 | Бичиг үсгийн хөтөлбөр | 13685.0 | 13684.9 | 0.10 | 100.00 |
| 81834 | Боловсролын стандарт, сургалт | 1062384.7 | 1020954.5 | 41,430.20 | 96.10 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 352464.6 | 338920.0 | 13,544.60 | 96.16 |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 753.0 | 753.0 | 0.00 | 100.00 |
| 83603 | Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 1150.7 | 1150.7 | 0.00 | 100.00 |
| 71802 | Ерөнхий боловсрол | 465869.1 | 453869.1 | 12,000.00 | 97.42 |
| | **Дүн** | **2,132,430.50** | **2,051,771.50** | 80,659.00 | 96.22 |

Орон нутгийн санхүүжилтээс төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байхгүй байна. Оны эцэст зарцуулагдаагүй 69.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөв аваагүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 161.6 сая төгрөгийн бараа материал, 39.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2684.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 26.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2139.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 21.4 сая төгрөг болж байна.

Буянт сумын Ерөнхий боловсролын н сургууль нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### 44.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав. Төсөв мөнгө, хөрөнгөтэй холбоотой 64.5 сая төгрөгийн 20 шийдвэрийг, 5.0 сая төгрөгнөөс дээш орлого бүхий 1600.4 сая төгрөгийн 17 гүйлгээг, 5.0 сая төгрөгнөөс дээш зарлага бүхий 708.7 сая төгрөгийн 18 гүйлгээг мэдээллийг Шилэн дансанд мэдээлсэн байна. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Ур чадвар олгох шалгуур үзүүлэлтийн дагуу хагас жил тутамд сургуулийн захирал нь шалгуур үзүүлэлтэд заасны дагуу хамт олны оролцоог хангаж багш, ажилтны ур чадварыг үнэлж байх ёстой боловч хэрэгжүүлээгүй, 2022 онд шинэчлэн баталсан шалгуурын дагуу үнэлгээ хийлгүй нийгмийн ажилтанд 3752.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.Үйлчилгээний албан хаагчдын ур чадварыг үнэлж дүгнэх ажил хийгдээгүй байсанд албан шаардлага өгөгдсөн байна.

Дээрх албан шаардлагын мөрөөр зөрчлийг арилган ажилласан бөгөөд, биелэлтийг нь хугацаанд тайлагнасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Албан шаардлага | 1 | 38752.9 | 1 | 38752.9 | 100% |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | 1 | 38752.9 | 1 | 38752.9 | 100% |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж цалин олголт, тогтоолтыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар цалинг үнэн зөв олгосон эсэхийг дахин шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 364,541.2 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч, 364,541.2 мянган төгрөгийг зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт гараагүй байна.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

1.1.Илрүүлэлт:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн бүгд 6,791.9 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 14.4.1,14.4.5, 14.4.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн зардлыг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

1.2 Илрүүлэлт:

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сургууль нь эм боох, бичиг хэргийн, аж ахуйн, түлш шатах тослох, үдийн хоол болон дотуур байрны хүнсний материалын, мал амьтадын нийт 162,973.6 мянган төгрөгийн, 176,338.3 мянган төгрөгийн зарлагын нярвын бараа материалын тайланг хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "*анхан шатны баримт бүрдүүлэх*", 14.3.2-д "*журналд бичих*", 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ "бүх орлого", "бүх зардал ", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалд Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтын нөхөх заавар"-ын 3 дугаар бүлгийн 9-д "бараа материалын тайлан" гэсэнд нийцэхгүй байна.

<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>

Няравын бараа материалын тайланг бараа материалын нэр төрөл тус бүрээр зохих журмын дагуу хөтөлж, тооцоо хийх.

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*<u>2.1 Илрүүлэлт</u>:*

Батлагдсан орон тоог Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан орон тооны жишиг нормативтай харьцуулж үзэхэд 2 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс 15,017.9 мянган төгрөгийн зардал гаргасан.

*Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/*

| д/д | Ажиллах албан тушаал | Орон тооны жишгээр | ажиллаж байгаа орон тоо | илүү орон тоо | жилийн дүнгээр авсан дүн /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Угаагч | 0 | 1 | -1 | 5,347.50 |
| 2 | Бэлтгэгч | 0 | 1 | -1 | 9,670.40 |
| | **Нийт дүн** | **0** | **2** | **-2** | **15,017.90** |

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр баталсан тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны "Төрийн албан зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан "Орон тооны жишиг норматив батлах тухай" гэсэнтэй нийцэхгүй байна.

*<u>2.1. Өгсөн зөвлөмж</u>*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан орон тооны жишиг нормативыг баримтлан ажиллах, илүү орон тооны асуудлыг тэтгэвэрт гарсан орон тоонд ажиллуулах замаар цэгцлэх,

***3. Хоолны зардлын нормативтэй холбоотой асуудал***

*3.2.Илрүүлэлт:*

Жилийн дүнгээр дотуур байрны хоолны зардалд нийт 94,644.7 мянган төгрөгийг зарцуулж, нэг хүүхдэд ноогдох нормативт зардлыг 3419.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 498 дүгээр тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 (дөрвөн мянга гурван зуун) төгрөгөөр, бага, дунд ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4000 (дөрвөн мянган) төгрөгөөр тус тус тогтоосугай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал”-тай, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 498 дугаар тогтоолд нийцэхгүй байна.

*3.2. Өгсөн зөвлөмж*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 498 дугаар тогтоолд нийцүүлэн батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | - | - | - | - | - | - | - | - | | | | |
| | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн | 4 | 364541.2 | | | | | 4 | 364541.2 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **364541.2** | | | | | **4** | **364541.2** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | **-** | **-** | **-** | **-** | **-** | | **-** | **-** |